



“ДУЛААНЫ ТАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ”
ОНӨААТҮГ

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

/Хамрах хугацаа: 2025.02.26-2025.12.31/



**"ДУЛААНЫ ТАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ" ОНӨААТҮГ-ЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

ТАНИЛЦСАН:

Дарга



А.Бямбадорж

Санхүү, эдийн засгийн албаны дарга

Б.Жавхлант-Од

БОЛОВСРУУЛСАН:

Захиргаа, хүний нөөцийн албаны дарга

М.Чинбат

АГУУЛГА

НЭГ. ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Товч танилцуулга	3
1.2. Удирдлага, бүтэц, зохион байгуулалт	3
1.3. Алсын хараа, эрхэм зорилго	5
1.4. Зорилтот зах зээл	6
1.5. Түншлэлийн төслийн танилцуулга	8
ХОЁР. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ	13
2.1. Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд гүйцэтгэсэн ажлын явц, үр дүн	13
ГУРАВ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ	14
3.1. Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилт	14
3.2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт, үр дүн	14
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ	17
4.1. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	17
4.2. Төсвийн зарцуулалтын хэрэгжилт	18
4.3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	19
4.4. Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	21
4.5. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	22
4.6. Архив, албан хэрэг хөтлөлтийн хэрэгжилт	23
4.7. Гэрээ, эрх зүйн чиглэлээр	25
4.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны хэрэгжилт	27
4.8. Дотоод хяналт, шинжилгээний хэрэгжилт	32
4.9. Төслийн бэлтгэл ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд	33
4.10. Бусад мэдээлэл	47

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

1.1. Товч танилцуулга

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт болох 4.2.34. Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг хангах дулааны цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөж, шинэ цахилгаан станц барьж дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортлох, Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлалд тусгагдсаны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар “Дулааны тавдугаар цахилгаан станц”-ыг барих асуудлыг судалж, танилцуулахыг даалгасан.

Уг шийдвэрийг хэрэгжүүлэх үүднээс Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 25/22 дугаар тогтоолоор “Дулааны тавдугаар цахилгаан станц” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулсан.

1.2. Удирдлага, бүтэц, зохион байгуулалт

Газрын өдөр тутмын үйл ажиллагааг дарга удирдана. Даргыг Нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.


Газрын бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтооно.

Газрын дарга Хөдөлмөрийн дотоод журам болон үйл ажиллагааны бусад дүрэм, журам, заавар зааварчилгааг батлах, Нийслэлийн Засаг даргаас баталсан бүтэц, орон тооны хүрээнд ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, сахилгийн шийтгэл оногдуулах, цалин хөлс, тэтгэмж, хөнгөлөлт урамшууллын хэмжээг тогтоох, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх зэрэг эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/316 дугаар захирамжаар “Дулааны тавдугаар цахилгаан станц” ОНӨААТҮГ-ын бүтэц, орон тоог нийт 25 хүний бүрэлдэхүүнтэй байхаар баталсан.



"ДУЛААНЫ ТАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ"
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН БҮТЭЦ



Захиргаа, хүний нөөцийн алба

Газрын стратеги төлөвлөгөө, бизнесийн төлөвлөгөөтэй уялдсан хүний нөөцийн бодлогын хүрээнд газрын удирдлагын манлайллыг хангахад чиглэсэн дотоод ажлыг зохицуулах, хүний нөөц төлөвлөлт, сургалт, хөгжил, бүрдүүлэлт, хөдөлмөрийн харилцаа, үнэлгээ, мэдээллийн систем зэрэг хүний нөөцийн үйл ажиллагааг удирдлагаар хангах, төлөвлөх, зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, архив, албан хэрэг хөтлөлтийг удирдах, зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах, хууль эрх зүй, гэрээний хэрэгжилтийг хянах зэрэг байгууллагын үйл ажиллагааг сайжруулан бусад бүрэн эрхийн хүрээнд ажиллана.

Санхүү, эдийн засгийн алба

Байгууллагын үндсэн зорилтыг хангах, үйлдвэрлэлийн болон бусад үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх, санхүү эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй болно.

Мөн байгууллагын санхүүгийн бодлого, төлөвлөлт, бүртгэл, хяналт, тайлан тооцоог боловсронгуй болгох, газрын хөрөнгө, түүний эх үүсвэр болон санхүүгийн үр дүн, мөнгөн хөрөнгө, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, үр ашигтай зарцуулалтанд хяналт тавих, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсронгуй болгож, тэдгээрт нийцсэн хөрөнгийн бүртгэл тооцоог хийх, санхүүгийн тайлан тэнцлийг гаргах, гаргасан тайланд анализ дүн шинжилгээ хийж, удирдлагын шийдвэр гаргалтанд мэдээ мэдээллээр хангаж ажиллах, хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн тооцоолол хийх болон хяналт тавих, эдийн засгийн үр ашигтай, оновчтой мөнгөн урсгалын зарцуулалтыг батлагдсан төсвийн дагуу төлөвлөлтийг хийн, түүний хяналтыг сайжруулж ажиллана.

Техник, технологийн алба

Эрчим хүчний тухай болон бусад холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн зорилго, стратеги төлөвлөгөөний дагуу "Дулааны тавдугаар цахилгаан станц"-ыг барьж ашиглалтад оруулах бүтээн байгуулалтын ажлын хүрээнд тоног төхөөрөмж, инженерийн барилга байгууламжийн тооцоо, зураг төсөл, угсралт, тохируулга болон ашиглалтад хүлээн авах үеийн техникийн үйл ажиллагаанд захиалагчийн техник хяналт тавьж, угсралтын ажлын чанарыг хангуулах, мэргэшлийн өндөр түвшинд удирдлагыг мэдээллээр хангах, найдвартай ажиллагааг хангах, ашиглалтыг сайжруулах, техник ашиглалтад судалгаа хийж, бүртгэл хөтлөх, дүгнэлт гаргах, техникийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх, үйлдвэрлэлд тэргүүний дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх зэрэг ажлуудыг удирдан зохион байгуулж ажиллана.

1.3. Алсын хараа, эрхэм зорилго

Алсын хараа:

"Монгол Улсын төвийн бүсийн эрчим хүчний найдвартай эх үүсвэр болж, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах үндэсний хэмжээний бүтээн байгуулалт болно."

Эрхэм зорилго:

“Дэвшилтэт технологид суурилсан, байгаль орчинд ээлтэй, өндөр үр ашигтай цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэх станц байгуулж, хэрэглэгчдийг тогтвортой, хүртээмжтэй эрчим хүчээр ханган, бүс нутгийн хөгжил дэвшлийг дэмжин ажиллах үлгэр жишээ үйлдвэр болох.”

1.4. Зорилтот зах зээл

Улаанбаатар хот болон төвийн бүсийн айл өрх, үйлдвэр, аж ахуйн нэгжүүд

- ❖ Орон сууцны хороолол, төрийн болон боловсролын байгууллагууд
- ❖ Ирээдүйд шинэ суурьшлын бүс, дэд бүтцийн хорооллууд

Бүс нутгийн дулаан болон цахилгааны эрэлт, хэрэгцээ

Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ТЭЦ-II, ТЭЦ-III, ТЭЦ-IV дулааны цахилгаан станц, Амгалан, Сэлбэ, Налайх дулааны станцаас бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг түүхий нүүрс хэрэглэхийг хориглож, сайжруулсан шахмал түлш, мидлинг (эрчим хүчний баяжуулсан нүүрс) хэрэглэхийг зөвшөөрсөн. Агаарын тухай хуулийн дагуу нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, бүсэд мөрдөх журмыг батлан хэрэгжүүлж байгаа боловч нийслэлийн агаар, орчны бохирдол төдийлөн буурахгүй байна.

Монгол Улсын эрчим хүчний зах зээлийн өнөөгийн төлөв байдлыг авч үзвэл, эрчим хүчний хэрэглээ жил бүр тогтвортой өсөж, үйлдвэрлэлийн хүчин чадал, хангамжийн эрэлт хоорондын зөрүү нэмэгдсээр байна. Монгол Улсын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ 2024 онд 8,754.7 сая кВт.ц болж өмнөх оны гүйцэтгэлээс 226.4 сая кВт.ц-аар буюу 2.7%-иар өссөн ба нийт цахилгааны 90.6%-ийг дулааны цахилгаан станцаар, 8.3%-ийг нар, салхины эх үүсвэрээр, 0.8%-ийг усан цахилгаан станцаар, 0.001%-ийг дизель станцаар тус тус үйлдвэрлэсэн байна¹. Дулааны цахилгаан станцуудын хүчин чадлын ашиглалтын дундаж үзүүлэлт 6,249,0 цаг болсон нь өмнөх жилүүдээс өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант онд 2,863,4 сая кВт.ц цахилгааныг импортоор авсан нь өмнөх онтой харьцуулахад 416,6 сая кВт.ц буюу 17%-иар өссөн байна. Нийт цахилгаан эрчим хүчний хэрэглээний дийлэнх хувийг төвийн эрчим хүчний сүлжээ хангаж байгаа бөгөөд үүнд Улаанбаатар хот болон томоохон аж үйлдвэрийн бүсүүдийн хэрэглээ өндөр хувийг эзэлж байна. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний дүнгээр 2024 онд 8,331,0 сая кВт.ц цахилгаан үйлдвэрлэж, 8,170,0 сая кВт.ц цахилгааныг түгээсэн нь өмнөх онтой харьцуулахад 133,6 сая кВт.ц буюу 1,6%-иар өссөн бол дулааны үйлдвэрлэл 10,608,6 мян.Гкал байгаа нь өмнөх оноос 252,9 мян.Гкал буюу 2.4%-иар өссөн. Эрчим хүчний үйлдвэрлэлийн дотоод хэрэглээний үр ашиг нэмэгдэж, төвийн бүсийн дулааны цахилгаан станцуудын дотоод хэрэгцээнд зарцуулсан цахилгаан 12.4 хувь болж, өмнөх оноос 0.1 нэгжээр буурсан байна. Энэ нь цахилгаан үйлдвэрлэлийн үр ашиг сайжирч байгааг харуулж байгаа боловч эрчим хүчний хэрэглээ өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор цахилгаан дамжуулалт, түгээлтийн үр ашгийг сайжруулах шаардлага улам бүр нэмэгдэж байна.

¹ Эрчим хүчний зохицуулах хорооноос эмхлэн гаргасан “Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд-2024”

Монгол Улсын эрчим хүчний гол эх үүсвэрүүд нь нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцууд бөгөөд нийт үйлдвэрлэлийн 90 гаруй хувийг эзэлж байна. Гэвч эдгээр станцуудын дийлэнх нь хуучирсан, ашиглалтын хугацаа дуусах дөхсөн тул шинэчлэл хийх шаардлагатай. Энэ нөхцөл байдал нь шинэ дэвшилтэт технологи бүхий цахилгаан станцуудыг ашиглалтад оруулах шаардлагыг улам бүр нэмэгдүүлж байна.

Монгол Улсын эрчим хүчний салбар нь нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцууд, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд, дизель үүсгүүрүүд гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрддэг. Улсын хэмжээнд нийт 1,664 МВт суурилагдсан хүчин чадалтай эрчим хүчний систем ажиллаж байгаа бөгөөд үүний 80 орчим хувийг нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцууд бүрдүүлдэг.

Монгол Улсын төвийн эрчим хүчний сүлжээнд эрчим хүчний хангамж, хэрэглээний зөрүү жилийн дундаж өсөлт 6-8% байгаа бөгөөд ойрын жилүүдэд энэ өсөлт нэмэгдэх хандлагатай байна. Иймд эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангах, өсөн нэмэгдэж буй хэрэгцээг даахуйц шинэ эх үүсвэрүүдийг барих шаардлагатай.

Үүнтэй холбоотойгоор, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах, нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах зорилготой сэргээгдэх эрчим хүчний төслүүд хөгжиж байгаа боловч тогтвортой үйлдвэрлэл, найдвартай хангамжийн баталгааны асуудлууд тулгарч байгаа нь дулааны цахилгаан станцуудын ач холбогдлыг хэвээр хадгалж байна.

Иймээс Дулааны тавдугаар цахилгаан станц (ДЦС-5)-ын төсөл нь Улаанбаатар хотын цахилгаан, дулааны хангамжийг сайжруулж, өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэгцээг хангах, агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулахын зэрэгцээ эрчим хүчний хараат байдлыг багасгаж, үндэсний эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангах, эрчим хүчний салбарт шинэ, өндөр бүтээмжтэй технологи нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм.

Эдийн засгийн хувьд эрчим хүчний салбар нь улсын хөгжилд чухал нөлөө үзүүлдэг стратегийн салбар бөгөөд өсөн нэмэгдэж буй аж үйлдвэржилт, хотжилт, барилгын салбарын хөгжил нь эрчим хүчний хэрэглээг улам нэмэгдүүлж байна. Төвийн бүсийн эрчим хүчний хангамжийн тогтвортой байдлыг хангах, эрчим хүчний алдагдлыг бууруулах, үйлдвэрлэлийн зардлыг бууруулахын тулд үр ашигтай технологи нэвтрүүлэх шаардлага өсөн нэмэгдэж байна. Засгийн газраас эрчим хүчний дэд бүтцийг өргөтгөх, шинэ эх үүсвэрүүдийг бий болгох бодлого баримталж байгаа нь салбарын хөрөнгө оруулалтын орчныг идэвхжүүлэх гол хүчин зүйл болж байна.

CO₂ ялгарлын хэмжээг авч үзвэл, 2024 онд нийт 11.9 сая тонн нүүрсхүчлийн хий ялгаруулсан нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд үүнээс хамгийн их ялгарлыг 6,0 сая тонноор ДЦС-4, 2,1 сая тонноор ДЦС-3 тус тус бүрдүүлсэн байна. Энэхүү үзүүлэлт нь байгаль орчинд ээлтэй, бага ялгаруулалттай технологи нэвтрүүлэх, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын өсөлтөд тулгуурлан хөгжиж байгаа боловч эрчим хүчний хүртээмж, тогтвортой байдал нь


эдийн засгийн өсөлтийг дэмжих, тогтвортой хөгжлийг хангах гол хүчин зүйлсийн нэг хэвээр байна.

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2024 оны эхний улирлын байдлаар 16.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.7 (19.4%) их наяд төгрөгөөр өссөн байна. Эдийн засаг 2023 онд 7.2 хувиар, 2024 оны эхний хагаст өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар өссөн². Эдийн засгийн өсөлтийн гол хөшүүрэг нь уул уурхай, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарууд бөгөөд эдгээр салбарын үйл ажиллагаанд эрчим хүчний хүртээмж, найдвартай байдал чухал үүрэг гүйцэтгэж байна. Эрчим хүчний хангамжийг сайжруулах нь аж үйлдвэрийн салбарын хөгжлийг дэмжих, улмаар эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Эрчим хүчний салбарын ДНБ-д эзлэх хувь 3.8% байгаа бөгөөд энэ үзүүлэлт уул уурхайн болон аж үйлдвэрийн хөгжлийн явцад нэмэгдэх хандлагатай байна. Дулааны тавдугаар цахилгаан станц төслийн хэрэгжилт нь эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, эрчим хүчний салбарын ДНБ-д эзлэх хувийг 1.5-2 нэгж хувиар өсгөх боломжтой. Үүний үр дүнд бусад салбаруудын өсөлтөд эерэг нөлөө үзүүлнэ.

1.5. Түншлэлийн төслийн танилцуулга

“Дулааны тавдугаар цахилгаан станц (ДЦС-5)” төсөл нь Улаанбаатар хотын цахилгаан, дулааны хангамжийг сайжруулж, өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэгцээг хангахын зэрэгцээ эрчим хүчний хараат байдлыг бууруулж, агаарын бохирдлыг багасгах, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үндсэн зорилготой бөгөөд энэхүү төсөл нь Монгол Улсын төвийн бүсийн эрчим хүчний системийн аюулгүй ажиллагааг хангах, цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх стратегийн чухал ач холбогдолтой төсөл юм.



Эрчим хүчний салбар бол Монгол Улсын үндэсний аюулгүй, бие даасан байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий хөгжлийн тэргүүлэх салбарын нэг. Манай улсын эрчим хүчний систем нь Төвийн бүсийн эрчим хүчний систем (ТБЭХС), Баруун бүсийн эрчим хүчний систем (ББЭХС), Алтай-Улиастайн эрчим хүчний

² Үндэсний статистикийн хорооноос эмхлэн гаргасан “Дотоодын нийт бүтээгдэхүүний 2024 оны эхний улирлын танилцуулга”


систем (АУЭХС), Дорнод бүсийн эрчим хүчний систем (ДБЭХС), Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ (ӨБЦТС) гэсэн таван хэсгээс бүрддэг.

2023 онд ОХУ-аас 938 сая кВт.ц, БНХАУ-аас 1.5 тэрбум кВт.ц, цахилгаан эрчим хүчийг худалдаж авсан бөгөөд импортын цахилгааны төлбөрт өнгөрсөн онд 197 сая ам.доллар буюу 678 тэрбум төгрөгийн төлбөр төлсөн байна.



Монгол Улсын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ 2023 онд 8.5 тэрбум кВт.ц болж өмнөх оны гүйцэтгэлээс 0.3 тэрбум кВт.ц-аар буюу 4.3 хувиар өссөн аж. Нийт цахилгааны 90.9 хувийг дулааны цахилгаан станцаар, 8.5 хувийг нар, салхины эх үүсвэрээр, 0.6 хувийг усан цахилгаан станцаар, 0.01 хувийг дизель станцаар тус тус үйлдвэрлэсэн байна. Тайлант онд 2.4 тэрбум кВт.ц цахилгааныг импортоор авсан нь өмнөх онтой харьцуулахад 0.3 тэрбум кВт.ц буюу 13.2 хувиар өсжээ.

2023-2024 оны өвлийн эрчим хүчний системийн оргил ачаалал өмнөх оноос 11.3 хувиар нэмэгдэж 1636 МВт-д хүрч, дулааны цахилгаан станцууд болон сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрүүд нөөц тоноглолгүй, бүрэн хүчин чадлаараа ажилласан. Цахилгаан дулааны эрчим хүчний үнэ бодит өртөгтөө хүрэхгүй байгаагаас шалтгаалж эрчим хүчний салбар 2024 онд 274 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллахаар байна. Мөн төвийн бүсийн дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр хангаж байгаа гурван нүүрсний уурхайн алдагдал 81 тэрбум төгрөг байх тооцоог албаныхан хийжээ.



Монгол Улсын хэмжээнд цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээ 2023 оны байдлаар 11 тэрбум кВт.ц байсан. Үүний 77.7 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, 22.3 хувийг импортоор худалдаж авсан байна. Өөрөөр хэлбэл, өмнөх 2022 оноосоо хэрэглэгчдийн цахилгааны хэрэглээ гурван хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлт. Манай улсын цахилгаан эрчим хүчний суурилагдсан хүчин чадал 1584 МВт байдаг. Үүнээс, 81 хувь нь дулааны цахилгаан станц, 19 хувь нь сэргээгдэх эрчим хүчний

үүсгүүр эзэлж байна. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний оргил ачаалал 2023 онд 1636 МВт хүрч 11 хувиар өссөн гэдгийг албанынхан онцолжээ.

Өнөөдрийн байдлаар нийт 19 дулааны цахилгаан станц, нарны болон салхин цахилгаан станц ажиллаж байгаа боловч “ДЦС-4” ТӨХК-ийн дангаараа Төвийн бүсийн нэгдсэн системийн нийт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн 60 гаруй хувийг нийлүүлдэг.

Дулааны эрчим хүчний үйлдвэрлэл Нийслэлд эзлэх хувь:

“ДЦС-2” ТӨХК: 276.2 мян.Гкал – 3.2%, “ДЦС-3” ТӨХК: 2,564.6 мян.Гкал – 30.1%, “ДЦС-4 ТӨХК: 4,636.9 мян.Гкал – 54.5%, “АДС” ТӨХК: 1,037 мян.Гкал – 12.2% тус тус дээд ачааллаар дулааны эрчим хүч үйлдвэрлэж байгаа бөгөөд нийт 8,514.7 мян.Гкал байна.

“Дулааны тавдугаар цахилгаан станц (ДЦС-5)” төсөл нь “Алсын хараа 2050”³ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр⁴ болон нийслэлийн дэд бүтцийн хөгжлийн бодлоготой бүрэн уялдсан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд хэрэгжиж буй томоохон төсөл гэдгээрээ онцлогтой.

Дулааны тавдугаар цахилгаан станц нь 2x150 МВт хүчин чадал бүхий хоёр блоктой байх бөгөөд агаар мандалд хаягдах утааны хийд агуулагдах NO_x, SO₂-г хянах хяналтын системтэй эргэлтэд буцлах үет шаталттай CFB технологитой зуух ашиглана. Уг станц нь усны хэрэглээг бууруулсан агаарын хөргөлттэй конденсатортой, хаягдал усаа эргүүлэн ашиглах технологитой усны хэрэглээг бууруулсан байгаль орчинд ээлтэй шийдэлтэй. Төсөл хэрэгжиж эхэлснээр жилд 2.2 тэрбум кВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба бүрэн хүчин чадлаараа ажилласан үед жилд дулааны ачаалал 4.8 сая ГДж байхаар ТЭЗҮ-ээр тооцоологдсон. Цахилгаан үйлдвэрлэлийн 90 хувь нь төвийн сүлжээнд нийлүүлэгдэж, үлдсэн 10 хувь нь станцын өөрийн дотоод хэрэглээнд зарцуулагдана.

Шинэ станцын байршил Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Дунд гол, 20-р хорооны нутаг дэвсгэрт, одоогийн байгаа станцаас баруун урд зүгт ойролцоогоор 400м зайд буюу ДЦС-2-ын үнсэн сангийн талбайд байна.

Төсөл хэрэгжсэнээр Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй цахилгаан, дулааны хэрэглээг бие даасан, найдвартай эх үүсвэрээр ханган, төвийн эрчим хүчний системийн ачааллыг бууруулж, дотоодын үйлдвэрлэлийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад хувь нэмэр оруулна. Улмаар эрчим хүчний дэд бүтцийг

³ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4.2.8 -т “Цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна” гэж,

⁴ Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2.2-т “Эрчим хүчээр хангагдсан хот” буюу нийслэл хотод бие даасан, тархмал цахилгаан, дулааны эх үүсвэрийг байгуулж, суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлнэ”, 1.1.2.3-т “Хүрэн нүүрсний ордыг түшиглэсэн 300 МВт-ын хүчин чадал бүхий дулааны цахилгаан станцыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулна.”, мөн 1.1.2.6-т “Дулааны II цахилгаан станц, Дулааны III цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн станцуудын хүчин чадлыг өргөтгөх төслийг хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан.

сайжруулж, цахилгаан түгээх, дамжуулах байгууламжуудыг шинэчлэх, эрчим хүчний хангамжийг найдвартай болгох, цахилгаан дамжуулах шугамын хүчин чадлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ орчин үеийн ухаалаг эрчим хүчний технологийг нэвтрүүлснээр Монгол Улсын эрчим хүчний салбарт технологийн шинэчлэлийг хурдасгах, цэвэр эрчим хүчний хөгжлийг дэмжинэ.

Тус төсөл нь орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан нүүрсний шаталтын үр ашгийг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй эрчим хүч үйлдвэрлэхэд чиглэгдсэн бөгөөд утааны хийн шүүлтүүрийн системийг суурилуулснаар агаар мандалд ялгарах дэгдэмхий үнсийг 99 хүртэлх хувиар бууруулах боломжтой. Мөн үнс зайлуулах системийг сайжруулж, хатуу хаягдлын менежментийг стандартын дагуу хэрэгжүүлэхээс гадна усны дахин боловсруулалтын технологи ашиглаж, үйлдвэрийн хаягдал усыг цэвэршүүлэн эргэлтэд оруулах, байгалийн усны хэрэглээг багасгах бодлого баримтална.

Төслийг хэрэгжүүлснээр Таван шар, 21 дүгээр хороо, Хилчин хотхон, Баянхошуу, 3, 4 дүгээр хороо, Нэгдүгээр хороолол зэрэг бүсүүдийн хэрэглэгчдийг дулаанаар хангаж, одоо ажиллаж буй станцуудын ачааллыг бууруулж, системийн дэд бүтцийн найдвартай ажиллагааг сайжруулна.

ДЦС-5 төсөл нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 15.1.1-т заасан “зураг төсөл, төсвийг боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх” төрлөөр хэрэгжих бөгөөд эрчим хүчний салбарт урт хугацааны тогтвортой шийдэл бий болгох зорилготой. Төслийн хөрөнгө оруулалтын нийт өртөг 658,563 сая ам.доллар бөгөөд нийт хөрөнгө оруулалтын 80 хувь нь хувийн хэвшлийн түншлэгчийн хөрөнгө оруулалт, 20 хувь нь Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт байна.

Түншлэлийн зүйл нь 2x150 МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станцын барилга байгууламж, үндсэн болон туслах тоног төхөөрөмж, дагалдах хяналт удирдлагын системээс бүрдэхээс гадна станцын бүрэлдэхүүн хэсэг, дэд бүтэц, шугам сүлжээ, туслах байгууламж болон дагалдах барилга байгууламжууд багтана.

Түншлэлийн гэрээний нийт хугацаа 27.5 жил бөгөөд үүнээс 2.5 жил нь барилга угсралтын үе шат, үлдсэн 25 жил нь ашиглалтын хугацаа байна.

Барилга угсралтын төлөвлөгөөгөөр үндсэн ажлууд 2025 оны 11 дүгээр сараас эхэлж, 2028 оны 5 дугаар сард дуусахаар төлөвлөгдсөн.

2026 онд геологийн судалгаа, ерөнхий төлөвлөлт, үндсэн тоноглолын захиалгыг гүйцэтгэх, мөн талбайн бэлтгэл, суурийн ажил, зуух, турбин, генератор зэрэг үндсэн тоноглолын суурилуулалт, нарийн төвөгтэй технологийн угсралт, автоматжуулалт, хяналт удирдлагын системийн холболт, туршилт тохируулгын бэлтгэл ажлууд хийгдэнэ. 2027 онд зуух, турбин, генераторын иж бүрэн угсралт, системийн холболт, суурилуулалт үргэлжилж, 2028 оны эхний хагаст туршилт, тохируулга хийгдэн станцын 1 болон 2 дугаар блокыг үе шаттайгаар ашиглалтад оруулахаар төлөвлөгдсөн.

Барилга угсралтын үе шатанд өндөр нарийвчлалтай инженерчлэл, тусгай мэргэжил, үйлдвэрлэгчийн стандарт, технологийн дамжуулалтыг зайлшгүй шаардах тул барилга угсралтын ажлыг төлөвлөсөн хугацаанд, чанарын шаардлагад

нийцүүлэн гүйцэтгэхэд гадаад мэргэжилтэн, инженерүүдийг тодорхой хугацаанд татан оролцуулах зайлшгүй шаардлагатай.

Энэхүү хэрэгцээнд үндэслэн 2026 онд барилга угсралтын ажлыг гүйцэтгэх хугацаанд нийт 1,600 гадаад инженер, мэргэжилтэн, техникийн ажилтныг төслийн хүрээнд ажиллуулах шаардлагатай гэж тооцоологдсон. Эдгээр ажиллах хүч нь суурь, хөрсний инженер, зуух, турбин, генераторын угсралтын инженер, төмөр хийц, гагнуурын нарийн мэргэжлийн ажилтан, автоматжуулалт, реле хамгаалалт, цахилгаан, дулаан, агааржуулалтын системийн инженерүүдээс бүрдэнэ. Тэдгээр нь байнгын бус, тодорхой хугацаанд, зөвхөн барилга угсралтын нарийн мэргэжлийн үе шатанд ажиллана.

Төслийн хэрэгжилтийн явцад дотоодын ажиллах хүч болон үндэсний аж ахуйн нэгжийн оролцоог үе шаттайгаар нэмэгдүүлэх зохицуулалтыг Түншлэлийн гэрээнд тусгасан. Барилгын үе шатанд дотоодын ажиллах хүчний оролцоог 10-аас доошгүй хувь байлгах, ашиглалтын эхний жилүүдэд шат дараатайгаар нэмэгдүүлж, 15 дахь жилээс эхлэн нийт ажиллах хүчний 75-аас дээш хувийг монгол ажилчид бүрдүүлэх зорилт тавьсан. Үүний хүрээнд симуляцийн сургалтын төв байгуулж, инженер техникийн ажилтнуудыг бэлтгэх, их, дээд сургуулиудтай хамтран дадлагажуулах, дотоодын мэргэжилтнүүдийг бие даан ажиллах чадвартай болгоно.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д зааснаар Засгийн газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын шийдвэрээр түншлэлийн гэрээний хүрээнд хувийн хэвшлийн түншлэгчид төрөөс дэмжлэг үзүүлэх боломжтой бөгөөд уг дэмжлэг нь хуульд заасан бусад хэлбэрээр хэрэгжиж болохоор зохицуулагдсан. Түүнчлэн төслийг хэрэгжүүлэх түншлэлийн гэрээний 20 дугаар зүйлийн 20.4-т *"Түншлэлийн хугацаанд жил бүр төслийн хэрэгжилтэд шаардлагатай гадаадын техникийн болон менежментийн ажилчдын ажиллах зөвшөөрлийг авах асуудалд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн⁵ дагуу төрийн түншлэгч дэмжлэг үзүүлнэ"* гэж тусгагдсан.

⁵ 12 дугаар зүйл. Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэг

12.1.3. дэд бүтэц, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, боловсролын салбарын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо, хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, холбогдох зөвшөөрлийг хөнгөвчилсөн горимоор олгох;

ХОЁР. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ

2.1. Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд гүйцэтгэсэн ажлын явц, үр дүн

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эдийн засаг бүлгийн зорилт 4.2-ын нэгдүгээр үе шат (2021-2030)-ны 8-д “Цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна”, мөн тус хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.34-д “Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг хангах дулааны цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөж, шинэ цахилгаан станц барьж дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортлох” гэж тус тус заасан.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.2.8-д “цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангана” гэж заасан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2.6-д “Дулааны II цахилгаан станц, Дулааны III цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн станцуудын хүчин чадлыг өргөтгөх төслийг хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан. Тус үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнан ажиллаж байна.

ГУРАВ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

3.1. Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилт

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 02 дугаар “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” албан даалгаврын 2.12-д “Улаанбаатар хотын дулаан, цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд “Дулааны хоёрдугаар цахилгаан станц”-ын дэд бүтцэд түшиглэн “Дулааны тавдугаар цахилгаан станц” барих асуудлыг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт” гэж тус тус даалгасан байдаг. Тус албан даалгаврын хэрэгжилтийн хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар “Дулааны тавдугаар цахилгаан станц” төслийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагыг байгуулах ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулсан.

Мөн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатлах тухай” албан даалгаврын хүрээнд байгууллагын аливаа худалдан авалт, тэтгэмж, урамшуулал зэргийг хязгаарласан. Түүнчлэн олон нийтийн арга хэмжээг он дуустал зохион байгуулалгүй ажиллав.

3.2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт, үр дүн

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/01 дүгээр тогтоолоор ТЭЦ-5 буюу Дулааны тавдугаар цахилгаан станц төсөл нь Нийслэл Улаанбаатар хотод төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтад багтсан байдаг.

Мөн Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/122 дугаар захирамжаар ТЭЦ-5 төслийг нэн яаралтай хэрэгжүүлэх төслийн жагсаалтад багтаасан.

Дээрх тогтоол болон захирамжийн хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 25/22 дугаар тогтоолоор “Дулааны тавдугаар цахилгаан станц” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг хавсралтаар баталсан. Үүний дагуу холбогдох материалыг бүрдүүлэн, төслийн байгууллагыг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт хуулийн дагуу бүртгүүлэх ажлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/316 дугаар захирамжаар байгууллагын бүтэц, орон тоог батлуулж ажилласан.

Байгууллагын төсвийн төслийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн бөгөөд улмаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 25/50 дугаар “Нийслэлийн 2025 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор байгууллагын төсөв батлагдсан.

Байгууллагын төсвийн сар, улирлын хуваарийг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/14 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн. Улмаар Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/458 дугаар “Санхүүжилтийн тухай” захирамжаар байгууллагын үйл ажиллагааны зардлыг сар, улирлын хуваарийн дагуу олгохыг зөвшөөрсөн.

Төсөлд бүрэн шинжилгээ хийх бэлтгэл ажлыг хангасны үндсэн дээр Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/490 дүгээр захирамжаар төслийн зураг төсөл, төсвийг “Боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх” (DBFOM) нөхцөлөөр хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, холбогдох журмын дагуу бүрэн шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/504 дүгээр захирамжаар төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах ажлыг зохион байгуулж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/689 дүгээр захирамжаар төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, шалгарсан түншлэгчтэй гэрээний хэлцэл хийх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах ажлыг зохион байгуулж ажилласан.

Төслийг эрчимжүүлэх ажлыг хурдан хугацаанд зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 25/84 дүгээр ““Дулааны тавдугаар цахилгаан станц” төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх тухай” тогтоолыг хэлэлцүүлэн батлуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/504, А/689 дүгээр захирамжаар байгуулагдсан Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг урьдчилсан болон уралдаант шалгаруулалтын баримт бичгийг түншлэлийн гэрээний төслийн хамт боловсруулж, Нийслэлийн Засаг даргаар батлуулсан. Ажлын хэсэг уралдаант шалгаруулалтыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Засгийн газрын 2024 оны 210 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Хувийн хэвшлийн түншлэгч болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/689 дүгээр захирамжаар баталсан Ажлын хэсгийн ажиллах удирдамж болон Нийслэлийн Засаг даргын баталсан “ДЦС5/202505” төслийн дугаартай “Дулааны тавдугаар цахилгаан станц (ДЦС-5) төслийн хувийн хэвшлийн түншлэгч сонгох урьдчилсан болон уралдаант шалгаруулалтын баримт бичгийн хүрээнд зохион байгуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/1223 дугаар захирамжаар сонгон шалгаруулалтын үнэлгээгээр эрэмбэлэгдсэн оролцогчтой гэрээний хэлэлцээр хийх, гол нөхцөл тохирох чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг нэгдүгээрт эрэмбэлэгдсэн оролцогчтой 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр гэрээний хэлэлцээг эхлүүлсэн бөгөөд хэд хэдэн удаагийн хэлэлцээрийн үр дүнд 09 дүгээр сарын 25-ны өдөр гэрээний төслийг харилцан тохиролцож, эцэслэсэн.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 11.1.5 дахь заалтын дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 25/125 дугаар тогтоолоор Дулааны тавдугаар

цахилгаан станц төслийн хувийн хэвшлийн түншлэгчтэй түншлэлийн гэрээ байгуулах эрхийг Нийслэлийн Засаг даргад олгосон. “Дулааны тавдугаар цахилгаан станц (ДЦС-5)” төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх түншлэлийн гэрээнд 2025 оны 11 дугаар сарын 13-ны өдөр төрийн түншлэгчийг төлөөлж Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, хувийн хэвшлийн түншлэгчийг төлөөлж “Митайм Интернэйшнл” ХХК-ийн Ерөнхий захирал Тиан Хаомин нар гарын үсэг зурж, баталгаажуулсан.

НИТХ-ын 2025 оны 12-р сарын 26-ны өдрийн 25/154 дүгээр тогтоолоор “ДЦС-5” ОНӨААТҮГ-ын дүрэмд өөрчлөлт оруулж, төслийн барилгын ажлын үе шатанд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг олгосон.

Нийслэлийн Засаг даргын “Түншлэлийн төсөлд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх тухай” захирамжийн төслийг боловсруулсан бөгөөд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраар холбогдох шийдвэрийг 2026 оны 01 дүгээр сарын эхэнд багтаан албажуулахаар ажиллаж байна.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ

4.1. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 25/22 дугаар тогтоолоор “Дулааны тавдугаар цахилгаан станц” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг баталсан.

Улмаар Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/316 дугаар захирамжаар тус байгууллагын зохион байгуулалтын бүтцийг баталж, орон тоог тогтоосон.

Захирамжийн дагуу байгууллага нь Техник, технологийн алба; Захиргаа, хүний нөөцийн алба; Санхүү, эдийн засгийн алба гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэ хугацаанд дор дурдсан арга хэмжээг авч ажиллаж байна:

Байгууллага шинээр байгуулагдсантай холбогдуулан ажилтнуудын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтыг баталж, албан тушаалын үндсэн цалинг тогтоон, албан тушаалд томилж, Хөдөлмөрийн гэрээг байгуулав.

Мөн ажилтнуудын хувийн хэргийн бүрдлийг тухай бүр хангуулж байна.

Газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/12 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг, 2 дугаар хавсралтаар Цалин хөлсний журмыг, мөн өдрийн А/13 дугаар тушаалаар Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг, 12 дугаар сарын 26-ны өдрийн А/53 дугаар тушаалаар Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг, мөн өдрийн А/54 дүгээр тушаалаар Ёс зүйн дүрмийг тус тус баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу газрын дарга, албаны дарга, нягтлан бодогч нар хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд мэдүүлэв.

Тайлант хугацаанд ажилтнуудыг чадавхжуулах хүрээнд дараах сургалтад хамруулаад байна:

1. 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран зохион байгуулсан shilen.gov.mn мэдээллийн системийг таниулах, албан хаагчдыг чадавхжуулах сургалтад 1 ажилтан хамрагдав.
2. 2025 оны 04 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд “Худалдан авах үйл ажиллагааны хөтөч” НҮТББ-аас зохион байгуулсан Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх цахим сургалтад холбогдох 3 ажилтан хамрагдаж, амжилттай суралцав.

4.4. Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Байгууллагын "2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Удирдах зөвлөлийн анхдугаар хуралдаанаар хэлэлцүүлж, 03 дугаар тогтоолын хавсралтаар баталсан.



"ДЦС-5" ОНӨААТҮГ-ын "2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г Монгол Улсын эрчим хүчний салбарын бодлого, нийслэлийн хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулсан. Энэхүү төлөвлөгөө нь "ДЦС-5" төслийг Төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ) хэлбэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагааг 2025 онд шат дараатай хэрэгжүүлэх зорилготой.

Төлөвлөгөөг боловсруулахдаа "ДЦС-5" ОНӨААТҮГ-ын дүрэмд заасан чиг үүрэг, бүтэц, үйл ажиллагааны эрх хэмжээ, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн засаглалын зарчимд үндэслэсэн.

№	Хариуцах нэгж	Төлөвлөгөөнд тусгагдсан нийт ажлын тоо	Үүнээс хамтран хэрэгжүүлэх
1	Захиргаа, хүний нөөцийн алба	11	11
2	Санхүү, эдийн засгийн алба	10	11
3	Техник, технологийн алба	23	-
4	Дотоод аудитор	6	-
5	ХАБЭА хяналтын инженер	21	1
	Нийт	71	-

Нийт 71 ажил, арга хэмжээ төлөвлөгөөнд туссан бөгөөд үүнээс 67 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнасан байна. Эдгээрийн биелэлт 92.3 хувьтай гарсан.

Түншлэлийн гэрээ төлөвлөгөөт хугацаанаас хойш байгуулагдсантай холбоотойгоор 4 арга хэмжээ 2026 оны төлөвлөгөөнд шилжин тусахаар болсон болно.

4.5. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал

“Шил ажиллагаа”-ны хүрээнд

Монгол Улсын Засгийн газраас "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон "Шинэ сэргэлтийн бодлого"-д дэвшүүлсэн төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, бүтээмжийг дээшлүүлэх, иргэдийн мэдэх эрхийн баталгааг хангах зорилтын хүрээнд "Шил ажиллагаа"-г хэрэгжүүлж байна.

"Шил ажиллагаа"-г авлига, хүнд суртлыг бууруулах, иргэд нээлттэй мэдээлэлтэй нэг цонхоор, саадгүй байдлаар танилцах, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг бүрдүүлэх, мэдээлэл хариуцагч байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдалд үнэлгээ хийж, "Шилэн индекс"-ийг зарлах зорилготойгоор хэрэгжүүлж эхэлсэн. Тус индексийн цахим платформ болох shilen.gov.mn веб хуудасд 2025 оны 4 дүгээр улиралд багтаан байгууллагын холбогдох мэдээллийг шинэчилж, 5 бүлгээр ангилан нийтэд ил тод байршуулж ажилласан.

Нүүр / Индексийн тайлан / Дулааны тавдугаар цахилгаан станц

Дулааны тавдугаар цахилгаан станц

Бусад

Тайлант үе:
2025 оны 4 улирал

№	Бүлгийн нэр	Шалгуур үзүүлэлтийн оноо				Нийт оноо	Хувь	
		МХБ	ХНБ	МБББ	ЭСТБ			
+	1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	275	450	150	150	1,025/ 2,040	50.25%
+	2	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	125	210	70	70	475/ 840	56.55%
+	3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	160	240	80	80	560/ 1,560	35.9%
+	4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал	0	0	0	0	0/ 0	0%
+	5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	120	180	60	60	420/ 960	43.75%

Шилэн данс

Шилэн дансны тухай хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо юм. Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн даган мөрдөж байна.

Шилэн дансны мэдээллийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

- Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;
- Мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх;
- Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;
- Хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх.

Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна.

- Шилэн дансны бие даасан цэстэй байх;
- Мэдээлэл татаж авах, хэвлэх боломжтой байх;
- Тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх;
- Мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх;
- Шилэн дансны мэдээллийг дуу болон дүрс бичлэгийн хэлбэрээр байрлуулж болно.

Шилэн дансанд тавигдах Төсвийн гүйцэтгэл хэмнэлт хэтрэлт, Цалингийн зардлаас бусад таван саяас дээш худалдан авалт, Харилцагч байгууллагын нэр, хаяг байршил, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Ашиг сонирхлын зөрчил, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн, Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан, Санхүүгийн тайлан гэх мэт мэдээ мэдээллийг тухай бүр холбогдох ажилтан албан хаагчаас нэгтгэн авч хуулийн хугацаанд шилэн дансны цахим системд байршуулан ажиллаж байна.

Мөн хүний нөөцийн батлагдсан орон тоон дахь хөдөлгөөнийг сар бүр шилэн дансанд байршуулан, хугацаа хэтэрсэн зөрчилгүй ажиллаж байна.

The screenshot displays the 'Шилэн дансны мэдээлэл' (Online Accounting) web application. The interface includes a header with the organization's name and logo, and a main content area with a table of transactions. The table has columns for 'Төсвийн төрөл' (Budget type), 'Хугацаа' (Period), 'Хэмжээ' (Amount), and 'Тайлбар' (Comments). The table contains several rows of data, including transactions for 'Төсвийн төрөл' and 'Хугацаа'.

4.6. Архив, албан хэрэг хөтлөлтийн хэрэгжилт

“Дулааны тавдугаар цахилгаан станц” ОНӨААТҮГ нь тайлант хугацаа буюу 2025 оны 02 дугаар сарын 26-наас 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд нийт 184 албан бичиг илгээж, 124 албан бичиг хүлээн авч, холбогдох хугацаанд нь шийдвэрлэлтийг хангаж ажиллалаа. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хугацаандаа шийдвэрлэсэн 123, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 1, шийдвэрлэх шатандаа 0 албан бичиг байна. Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь 98.1 хувь “А” үнэлгээтэй байна.

Албан бичиг шийдвэрлэлтийн мэдээ:

№	Хэлтэс	Нийт	Шийдвэрлэсэн		Шийдвэрлэх шатандаа	
			Хугацаандаа	Хугацаа хэтэрсэн	Судалж байгаа	Хугацаа хэтэрсэн
1	Захиргаа, хүний нөөцийн алба	71	71	0	0	0
2	Санхүү, эдийн засгийн алба	25	24	1	0	0
3	Техник, Технологийн алба	22	22	0	0	0
4	Дотоод Аудитор	4	4	0	0	0
5	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын инженер	2	2	0	0	0
НИЙТ		124	124	0	0	0

Хариутай албан бичгийн шийдвэрлэлт:

Тайлант хугацаанд нийт хариутай 22 албан бичиг бүртгэж, хүлээж авсанаас хугацаандаа шийдвэрлэсэн 21, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 1, шийдвэрлэх шатандаа 0 албан бичиг байна. Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь 97,5 хувь буюу “А” үнэлгээтэй байна.

	Хэлтэс	Нийт	Шийдвэрлэсэн		Шийдвэрлэх шатандаа	
			Хугацаандаа	Хугацаа хэтэрсэн	Судалж байгаа	Хугацаа хэтэрсэн
1	Удирдлага	1	1	0	0	0
2	Захиргаа, хүний нөөцийн алба	15	15	0	0	0
3	Санхүү, эдийн засгийн алба	5	4	1	0	0
4	Техник, технологийн алба	1	1	0	0	0

Мөн тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагаа болон хүний нөөцийн чиглэлээр газрын даргын тушаалыг архив, албан хэрэг хөтлөлтийн холбогдох журам, стандартыг мөрдлөг болгон боловсруулж ажиллалаа.

“ДЦС-5” ОНӨААТҮГ-ын газрын даргын А тушаал:

1. Ажлын байрны тодорхойлолт батлах тухай -1
2. Үндсэн цалин тогтоох тухай -1
3. Төлөвлөгөө батлах тухай -1
4. Байгууллагын тамга тэмдэг түших тухай -1

5. Шилэн дансны цахим хуудасны мэдээлэл хөтлөх тухай -1
6. Нэг удаагийн тусламж олгох тухай - 1
7. Жагсаалт батлах тухай -1
8. Индекс батлах тухай -1
9. Ажлын хэсэг байгуулах - 14
10. Үнэлгээний хороо байгуулах тухай -3
11. Хөрөнгө зарцуулах тухай -16
12. Журам батлах тухай -4
13. Дүрэм батлах тухай -2
14. Томилолтоор ажиллах, удирдамж, төсөв батлах тухай-2
15. Албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан тушаалын жагсаалт батлах тухай -1
16. Тооллогын комисс байгуулах тухай -2
17. Өмч хамгаалах байнгын зөвлөл байгуулах тухай -1
18. БНШК байгуулах тухай -1

“ДЦС-5” ОНӨААТҮГ-ын газрын даргын Б тушаал:

1. Албан тушаалд томилох тухай - 19
2. Албан тушаалд түр томилох тухай - 1
3. Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгах тухай - 2
4. Нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай - 18
5. Нууц хамгаалах ажилтнаар томилох тухай - 1
6. Ээлжийн амралтын хуваарь батлах тухай - 1
7. Нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай - 1

Тамга тэмдэг ашиглалт, хамгаалалтын хүрээнд:

Байгууллагын тамга тэмдгийг тогтсон журмын дагуу бат бөх цоожтой сейфэнд хадгалах, бусдад дамжуулахгүй байх зэрэг хадгалалт, хамгаалалтыг хариуцаж, Байгууллагын хэмжээнд байгууллагын тэмдэг 1ш, хуулбар хувь тэмдэг 1, боловсруулсан дардас 1 ширхэг, ирсэн бичиг бүртгэх тэмдэг 1 ширхэгийг тус тус хэрэглэж, тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллаж байна.

Бичиг, баримтын бүрдлийг шалган, архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох стандартын дагуу гүйцэтгэж удирдлагын гарын үсэг зурагдан зөвшөөрөгдсөн тохиолдолд тамга дарж ажилласан.


4.7. Гэрээ, эрх зүйн чиглэлээр

2025 оны байдлаар худалдах, худалдан авах гэрээ, зөвлөх үйлчилгээний гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ зэрэг нийт 30 орчим гэрээг хянан баталгаажуулсан.

Авлигын эсрэг үндэсний хөдөлгөөний хүрээнд

АТГ-ын даргын тушаалаар батлагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтын дагуу 4 албан тушаалтны 2024 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг холбогдох дүрэм, журмын хүрээнд зохион байгуулан ХАСХОМ-1, ХАСХОМ-2 болон бусад тайлангуудыг Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 91 дүгээр тушаалаар баталсан хавсралтуудын дагуу гарган НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн болно.

“Авлигын эсрэг нэгдье” аянг дэмжиж, аяны талаарх мэдээллийн зурагт хуудсыг байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст байршуулж, олон нийтэд сурталчилсан. Мөн нийслэлийн ERP системд байршуулсан болно.



Жендерийн тэгш байдал, хүний эрх


Нийслэлээс жендерийн эрх тэгш байдлыг хангах, хүний эрх, жендерийн боловсрол олгох, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүрээнд “Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аян”-д нэгдлээ.

Жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсооход олон нийтийг татан оролцуулах зорилгоор НҮБ-аас 16 хоногийн аяныг 1991 оноос эхлэн жил бүр 11 дүгээр сарын 25-аас (Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох өдөр) 12 дугаар сарын 10 (Хүний эрхийн өдөр)-ны хооронд тодорхой уриалга дэвшүүлэн зохион байгуулсаар ирсэн.

Энэ жилийн аян "Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд нэгдье" уриатайгаар явагдаж байгаа юм.

Аяны талаарх мэдээллийн зурагт хуудсыг байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст байршуулж, олон нийтэд сурталчилсан. Мөн нийслэлийн ERP системд байршуулан ажилласан болно.

Мөн байгууллагын хэмжээнд “Жендэр ба хүний эрх” сургалт, хэлэлцүүлийг ажилтнууд дунд зохион байгуулж ажиллав.



4.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны хэрэгжилт


I ХЭСЭГ. ЗОРИЛТ, ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

4.6.1. Зорилго, зорилтын биелэлт

№	Зорилт	Суурь үзүүлэлт	Зорилтот үзүүлэлт	Биелэлтийн хувь	Хүрсэн үр дүн
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, стандарт, дүрэм журмын хэрэгжилтийг хангах	0%	100%	100%	ХАБЭА-тай холбоотой хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын 21 ажлыг төлөвлөсөн. 21 заалт бүхий төлөвлөгөөний биелэлт 100% байна.


4.6.2. Үйлдвэрлэлийн осол (улсын байцаагчаар хянагдаж батлагдсан)

Үйлдвэрлэлийн осол 2025 оны байдлаар:



ТАЙЛБАР: 2025 оны үйлдвэрлэлийнн ослыг сараар харьцуулсан судалгааг харуулав.

Аюултай тохиолдол



ТАЙЛБАР: 2025 оны байдлаар аюултай тохиолдол бүртгэгдээгүй.

4.6.3. Осол, мэдээлэл даалгавар, түүний гүйцэтгэл

2025 оны байдлаар "Ослын мэдээлэл даалгавар" гараагүй.

4.6.4. Сэрэмжлүүлэг мэдээ

2025 оны байдлаар “Ослын мэдээлэл даалгавар” гараагүй.

4.6.5. Гурван шатны үзлэгийн үр дүн /илэрсэн зөрчлийн тоо, залруулсан байдал/

Гуравдугаар шатны хяналт:

Үзлэгийн давтамж	Илэрсэн зөрчлийн тоо	Залруулсан зөрчлийн тоо	Гүйцэтгэл	Үзлэгийн сэдэв
2-р улирал	3	3	100%	Хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагыг хангуулахад хяналтын зорилго оршино.

ТАЙЛБАР: Ажлын байрны Гуравдугаар шатны үзлэгийг төв оффист хийж 3 зөрчлийг арилгасан.

4.6.6. Хөдөлмөрийн аюулгүй байдлын зөрчил

2025 оны байдлаар байгууллагын дотоод дүрэм, журам, холбогдох хууль зөрчсөн ажилтнууд байхгүй.

4.6.7. Аюулыг мэдээлэх хуудас

2025 оны байдлаар аюулыг мэдээлэх хуудсаар лифттэй холбоотой 1 аюул мэдээлэгдсэн байна. Түрээслэгч эзэнд зөрчлийг яаралтай устгах тухай бичиг цахимаар хүргүүлсэн.

Аюулын зэргийг графикаар үзүүлбэл:



4.6.8. Эрсдэлийн үнэлгээ

“Дулааны тавдугаар цахилгаан станц” төсөл нь Улаанбаатар хотын эрчим хүчний хэрэгцээг хангах, эрчим хүчний хараат байдлыг бууруулах, дэвшилтэт технологид суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор хэрэгжих бөгөөд

төслийн хүрээнд эрсдэлийн үнэлгээний ажил төслийн бүх үе шатыг хамарсан байдлаар, өргөн хүрээнд хийгдсэн болно.

Энэхүү үнэлгээнд төслийн бэлтгэл хангах шат, барилга угсралтын шат, ашиглалтын шат болон стратегийн орчны (SWOT, PESTEL) хүчин зүйлсийг хамруулан нийт 159 нөхцөл байдал, хүчин зүйлийг ангилан үнэлсэн. Үүнээс:

- Маш ноцтой эрсдэл – 11,
- Ноцтой эрсдэл – 82,
- Дунд зэргийн эрсдэл – 66 нөхцөлд хамаарсан байна.

4.6.9. Наряд, шийдвэр, цоож пайз

“Дулааны тавдугаар цахилгаан станц”-ын төсөл нь бичиг баримтын үе шат дээр явж байгаа тул наряд, шийдвэр, цоож пайзны систем хэрэгжиж эхлээгүй байна.

4.6.10. Зааварчилгаа

